

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь Монгол Улсын иргэн татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, үйл ажиллагааны болон шууд бус орлого, иргэний бусад орлогод ногдуулах хувь хүний орлогын албан татварын хэмжээг нэг хувь болгон бууруулснаар татвар төлөгч иргэдийн татварын ачааллыг хөнгөлж дундаас дээш орлоготой өрхийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо нэмэгдэнэ гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан хууль батлагдсанаар өрхийн орлого болон иргэдийн амьдралд үзүүлэх нөлөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 100 мянган иргэний гарын үсэгт үндэслэн санаачилсан хувь хүний орлогын албан татварыг нэг хувь болгон бууруулахыг дэмжиж байгаагаа илэрхийлж, энэ төсөл нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн зорилго, агуулгатай нийцэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төслийг төсвийн жилийн дундуур өргөн мэдүүлсэн нь Татварын ерөнхий хуульд тусгагдсан татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулах зохицуулалттай нийцэж байгаа эсэх, мөн иргэдийн хэдэн хувь нь дунджаас дээш болон доош орлоготойг тодруулж, хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг бууруулснаар орон нутгийн төсвийн орлогын бууралтыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хувь хүний орлогын албан татварыг бууруулснаар орлогын түвшингийн ангиллаас хамаарч иргэдэд үзүүлэх татварын нөлөөллийн судалгаа хийгдсэн эсэх, мөн орон нутгийн төсвийн орлогын дийлэнх хувийг хувь хүний орлогын албан татвараас бүрдүүлж байгаа тул орлогын эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын Н.Алтанхуяг хувь хүний орлогын албан татварыг бууруулж нэг хувь болгохыг дэмжиж байгаагаа илэрхийлж, татварын бодлого, төсвийн зохицуулалттай холбоотойгоор Засгийн газар үнийн өсөлт болон төсвийн зарцуулалтын талаар олон нийтэд хэрхэн танилцуулж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир

өрхийн орлого зарлагаасаа доогуур байгаа өнөөгийн нөхцөлд хувь хүний орлогын албан татварыг нэг хувь болгон бууруулснаар иргэдийн амьжиргааг дэмжихэд хэрхэн нөлөөлөх, мөн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ямар үр дүн үзүүлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хувь хүний орлогын албан татварыг бууруулах хуулийн төслийг дэмжиж байгаа ч орлогоос хамааруулан татвар ногдуулалтыг шатлалтайгаар тогтоох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа хувь хүний орлогын албан татварыг нэг хувь болгохыг дэмжиж байгаа бөгөөд өндөр татвар төлсөн иргэдэд буцаан олголтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, А.Ганбаатар нар хувь хүний орлогын албан татварыг нэг хувь болгосноор иргэдийн мөнгөн орлого болон дотоодын зах зээл дэх мөнгөн урсгал нэмэгдэх тул хуулийн төслийг дэмжиж байгаа талаар тус тус санал хэлсэн болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 47.1 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР